



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/53

Есөнбулаг сум


Дансны үлдэгдэл буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 243 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд 2025 оны жилийн эцэст орон нутгийн төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн хавсралтад дурьдсан байгууллагуудын нийт 49,707,979.50 (дөчин есөн сая долоон зуун долоон мянга есөн зуун далан есөн төгрөг тавин мөнгө) төгрөгийг буцаан олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Л.Хаш-Эрдэнэ), төсвийн ерөнхий нягтлан бодогч (Д.Ундрахбаяр)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны  
01 дугаар сарын 26-ны өдрийн 1/53 дугаар  
захирамжийн хавсралт

| № | Байгууллагын нэр                  | Мөнгөн дүн    |
|---|-----------------------------------|---------------|
| 1 | Аймгийн Засаг даргын Тамгын газар | 20,968,167    |
| 2 | Байгаль орчны газар               | 7,827,000     |
| 3 | Төрийн архивын тасаг              | 7,412,812.50  |
| 4 | Ойн анги                          | 13,500,000    |
|   | Нийт дүн                          | 49,707,979.50 |

\_ оОо \_

